

**“БОГД БАНК ХК-ЫН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН РОЖЕР ТОМАС МОЙЕСИЙН 2022 ОНЫ 4-Р УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН”**

Миний бие Рожер Томас Моеэс нь Монголбанкны 2022.09.14-ны өдрийн А-1/981 албан бичгийн зөвшөөрлийн дагуу Богд Банк ХК-ийн ТУЗ-ын Хараат бус гишүүнээр томилогдож 2022 оны 09 дүгээр сарын 29-нд Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хуралд өөрийн биеэр зайнаас оролцож ТУЗ-ийн дэргэдэх Хүний нөөцийн хорооны дарга
ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, үнэлгээ урамшууллын хорооны гишүүн
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүнээр тус тус томилогдон ажиллаж байна.

Тайлант хугацаанд ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллаж журмын дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

1. Аудитын хороо:

Аудитын хорооны 2022.11.23-ны өдрийн хурлаар тус хорооны ерөнхий ажиллах журам, үйл ажиллагаатай танилцаж дараах асуудлыг хэлэлцэж, саналаа өгч ажилласан.

1. ДАГ-ын үйл ажиллагаа, төлөвлөгөөний биелэлт, өгөх дүгнэлт.
2. АХ-д гишүүн нэмэх тухай.
3. Чанарын баталгаажуулалтын тайлан, анхаарах асуудал.
4. “Дотоод аудитын бодлого”-ын төсөл.

2. Хүний нөөций хороо:

Тус хороо одоогоор 3 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа ба

Тайлант хугацаанд хүний нөөцийн хороог 1 удаа хуралдуулж дараах асуудлыг хэлэлцсэн.

1. Банкны хүний нөөцтэй холбоотой мэдээлэл, танилцуулга.
2. ТУЗ-ийн даргыг шагналд тодорхойлох.

Тус хурлаар Банкны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангахтай холбоотой журам дүрэмтэй танилцаж, хянан хэлэлцэж одоо мөрдөгдөж байгаа Хүний нөөцийн хорооны ажиллах журамтай танилцсан.

3. Нэр дэвшүүлэх, үнэлгээ урамшууллын хорооны гишүүн

2022 оны 12 дугаар сарын 16-нд ТУЗ-ийн хурлаад батлагдсан Нэр дэвшүүлэх, үнэлгээ урамшуулалын хорооны журмын боловсруулалт санал зөвлөмжийг өгч журмыг дараах чиг үүргийн хүрээнд баталж мөрдөн ажиллаж байна.

- ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг тодорхойлох;
- Компанийн хэмжээнд цалин, урамшууллын бодлогыг тодорхойлох, хэрэгжилтэнд нь хяналт тавих;
- Компанийн цалин, урамшууллын бодлоготой холбоотой асуудлаар ТУЗ-д дүгнэлт, санал гаргах, асуудлыг шийдвэрлүүлэх

2022 оны 04 дүгээр улиралд ТУЗ-ийн нийт 22 удаагийн хуралд оролцсон ба уг хурлуудаар Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журмын 5.2.3 дах заалтын дагуу Их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах

2022.10.07-ны Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай - 1 тогтоол

2022.11.03-ны Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай – 1 тогтоол

2022.12.13-ны Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай – 3 тогтоол

2022.12.26-ны Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай – 2 тогтоолд тус тус санал өгч оролцсон байна.



**“БОГД БАНК ХК-ЫН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
РОЖЕР ТОМАС МОЙЕСИЙН 2022 ОНЫ 4-Р УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН”**

Хараат бус гишүүний чиг үүргийн дагуу хороодын ажлын чиг үүргийн хүрээнд холбогдох нэгжүүдтэй ойрхон ажиллаж, энэ чиглэлээр ТУЗ болон Банкны удирдлагад зөвлөмж өгч ажиллаж байна.

Цаашид Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журмын 5 дугаар заалтын дагуу өөрийн хариуцаж байгаа өөрийн хийж гүйцэтгэсэн ажлыг журмын дагуу хариуцлагатайгаар гүйцэтгэж тайлагнан ажиллах болно.

БОГД Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
2023.01.09

Рожер Томас Мойес